



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/331

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулий 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жаргалант сумын Цамбагарав багт байрлах, худалдаа, үйлчилгээний зориулалттай “Мянган-Угалзат” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /4067088/-ын эзэмшлийн 2224 метр квадрат газраас 1098 метр квадрат газрыг Гадаадын иргэн, харьяатын газар, Баруун бүс дэх газар /4081676/-т хаягийг Ану хатан 1 дүгээр гудамжны 112 б тоот болгон албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар, үлдсэн 1126 метр квадрат газрыг “Мянган-Угалзат” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /4067088/-т хаягийг Ану хатан 1 дүгээр гудамжны 112 а тоот болгон албан хэрэгцээний зориулалтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх аж ахуй нэгжид үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02-1017